



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/596

Есөнбулаг

Алтайн малчдын зөвлөгөөний
шийдвэр хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.1.5 дахь зорилт, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.5 дахь зорилт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэржилтийн сэргэлт, "Малчдыг дэмжих анхдугаар аян"-ы хүрээнд "Алтайн малчдын түншлэл" малчдаас бүрдсэн ажлын хэсгийн төлөөлөл хавсралтад заасан нэр бүхий хүмүүсийг Улаанбаатар болон Өвөрмонголын өөртөө засах орны Шилийн гол аймагт туршлага судлах ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг батлагдсан эх үүсвэрээс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2.Туршлага судлах ажлыг хариуцан ажиллах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, зохион байгуулах ажлын удирдамж, хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар, зарцуулагдах хөрөнгийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тус ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, нэгдсэн удирдлагаар хангаж, үр дүнтэй зохион байгуулан дүнг танилцуулахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20~~22~~²³ оны
10 дугаар сарын 30 ны өдрийн 4/5 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Ш.Эрдэнэбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Ажлын хэсгийн гишүүд: Л.Хаш-Эрдэнэ (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Х.Баатарзориг (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Т.Төгсжаргал (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Хэвлэлийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуй газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

__оОо__

Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 20 өдрийн 1 дугаар
Захирамжийн хоёрдугаар хавсралт

ТУРШЛАГА СУДЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ, ХӨТӨЛБӨР


2023.10.30

Алтай хот

Д/Д	Үйл ажиллагаа	Он, сар, өдөр	Цаг
1.	Аймагт цугларах	2023.11.06	-
2.	Говь-Алтай аймгаас хөдлөх	2023.11.07	-
2023.11.08-9-ний өдрийн үйл ажиллагаа			
3	Өвөрмонголруу хөдлөх бүтэн өдөр Шилинхот (Mengxiya зочид буудал)	2023.11.08	08:00
4	Өглөөний цай	2023.11.09	08:00
5	Баруун Ужмичин руу хөдлөх	2023.11.09	09:00
6	Баруун Ужмичин хошуу орчин үеийн тэжээлийн нөөц, боловсруулалт нийлүүлэлтийн бааз	2023.11.09	10:30
7	Баруун Ужмичин инноваци, энтрепренёршиппийн инкубацийн бааз		
8	Үдийн хоол (Ужмичин зочид буудал)	2023.11.09	11:30
9	Баруун Ужмичин, Ужмичинхаол хот, Тугаоле хотхоны Наоганбао Лигагаяа (Хятад үндэстэний цөөнхийн онцлогтой тосгон)руу хөдлөх	2023.11.09	13:00
10	Сургалтын аялал: 1.Мэргэжлийн мал ахуй эрхлэгчид 2.Морь үржүүлгийн мэргэжлийн хүмүүс 3.Мэргэжлийн хонины аж ахуй эрхлэгчид	2023.11.09	14:00
11	Оройн хоол (Ужмичин зочид буудал)	2023.11.09	18:00
2023.11.10-ны өдрийн үйл ажиллагаа			
12	Өглөөний цай	2023.11.10	08:00
13	Шилинхот руу хөдлөх	2023.11.10	09:00
14	Зочлох, судлах 1.Xilingol league Maodengcao мал аж ахуйн парк 2.Симментал үхрийн махны супермаркет	2023.11.10	10:30
15	Үдийн хоол	2023.11.10	12:00
16	Сургалтын аялал 1. Өвөрмонголын Йиму Жилиан технологи ХХК (Мал нөхөр)	2023.11.10	14:30
17	Оройн хоол (Абага зочид буудал)	2023.11.10	19:00
2023.11.11-ний өдрийн үйл ажиллагаа			
18	Өглөөний цай	2023.11.11	08:00
19	Зочлох хичээл заах: Абагабаннер Цеге үйлдвэрлэлийн бааз	2023.11.11	09:00
20	Sunit left Banner руу хөдлөх	2023.11.11	10:00
21	Үдийн хоол (Sunit Zuоqi зочид буудал)	2023.11.11	11:30
22	Сургалтын аялал: 1. Чаган Аобао хотхон Рибоолагэ Гача мал аж ахуйн үйлдвэрлэлийн нийгэм үйлчилгээний бааз 2. Sunit Left Banner Mandu Latu Meat Food	2023.11.11	13:30
23	Оройн хоол	2023.11.11	18:00
2023.11.12-ны өдрийн үйл ажиллагаа			
24	Өглөөний цай	2023.11.12	08:00
25	Эрээн хотруу хөдлөх	2023.11.12	09:00

Аймгийн Засаг даргын 2023 оны
10 дугаар сарын 20-ны өдрийн 7/57 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

ЗАРЦУУЛАГДАХ ХӨРӨНГИЙН ЭХ
ҮҮСВЭР



Д/д	Батлагдсан нэр	Батлагдсан төсөв	Зарцуулагдсан хөрөнгө	Зарцуулагдах хөрөнгө
Алсын хараа-2050", Шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэржилт болон хот хөдөөгийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд				
1	Мал аж ахуй, түүхий эдийг боловсруулах дотоодын үйлдвэрүүдтэй танилцах, туршлага судлах	19,000,000		19,000,000
2	Мал аж ахуй, түүхий эдийг боловсруулах гадаадын үйлдвэрүүдтэй танилцах, туршлага судлах	45,000,000	4,744,000	40,256,000
3	Хэвлэл мэдээллийн зардал	18,000,000		18,000,000
	Нийт дүн	82,000,000	4,744,000	77,256,000

__оОо__